

МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 1 дүгээр сар

ХУРААНГУЙ:

- Мөнгөний нийлүүлэлт 1.6 хувиар буурч 11.9 их наяд төгрөг болжээ. Үүнд М1 мөнгө 6.6 хувиар буурсан нь гол нөлөө үзүүлэв. Тухайлбал, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 11.0 хувь, төгрөгийн харилцах 5.0 хувиар буурчээ.
- Иргэд гадаад валютын хадгаламжаа төгрөгийн хадгаламж руу шилжүүлэх хандлага ажиглагдлаа.
- Тайлант сард нөөц мөнгө 226.3 тэрбум төгрөгөөр буурч 2838.1 тэрбум төгрөг болжээ. Үүнд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 138.8 тэрбум төгрөгөөр буурсан нь гол нөлөө үзүүлэв.
- Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл 16.4 их наяд төгрөг болсон бөгөөд үүний 48.3 хувь иргэдэд, 45.0 хувь хувийн хэвшилд, 6.6 хувь улсын байгууллагуудад олгосон зээл байна.
- Тайлант сарын эцэст санхүүгийн байгууллагуудын зээлийн 10.2 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.6 хувь нь чанаргүй гэж ангилагджээ.

МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2014	2015	2016				2017
	12-р сар	12-р сар	3-р сар	6-р сар	9-р сар	12-р сар	1-р сар
Мөнгө, санхүүгийн сектор							
Нөөц мөнгө, тэрбум ₮	3,502.0	2,519.5	2,422.3	3,585.0	3,164.9	3,487.7	2,838.1
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	27.1	17.4	2.2	9.8	-4.8	-1.7	-7.4
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	5.0	-28.1	-4.9	47.5	27.1	38.4	22.8
М2 мөнгө, тэрбум ₮	10,634.7	10,049.0	10,112.4	11,186.4	11,555.9	12,076.5	11,880.7
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	7.1	2.5	1.0	5.0	1.6	3.0	-1.6
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	12.5	-5.5	2.1	11.4	16.3	20.2	20.6
Бусад хадгаламж, тэрбум ₮	8,817.9	8,363.6	8,528.7	9,204.2	9,535.3	9,986.4	9,928.3
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	7.0	1.4	0.5	3.3	1.5	1.9	-0.6
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	19.8	-5.2	0.9	9.9	14.6	19.4	20.5
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, тэрбум ₮	809.7	706.7	658.6	839.2	795.8	823.6	736.1
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	5.3	-0.5	0.5	6.5	-2.6	7.1	-10.6
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	-3.7	-12.7	-6.3	11.0	3.6	16.6	3.1
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	16599.5	17,932.8	18,430.3	18,410.2	19,240.1	16,449.1	16,367.5
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	2.7	0.5	1.5	1.7	0.6	-16.7	-0.5
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	31.2	10.9	11.5	8.1	8.0	-8.3	-9.4
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	12,503.5	11,706.6	11,835.5	12,030.4	12,490.9	12,422.2	12,379.5
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	-1.2	-1.6	1.7	5.1	0.4	-2.3	-0.3
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	16.1	-6.4	-3.6	0.6	4.6	6.1	5.0
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, тэрбум ₮	625.7	869.8	967.9	1,035.6	1,119.3	1,051.7	1,056.2
<i>сарын өөрчлөлт, хувиар</i>	0.9	0.5	6.2	-2.6	-0.6	-9.9	0.4
<i>жилийн өөрчлөлт, хувиар</i>	10.6	39.0	37.7	33.8	31.3	20.9	18.1
Мөнгөний үржүүлэгч	3.04	3.99	4.17	3.12	3.43	3.96	4.19
Хүү							
Хадгаламжийн ЖДХ	12.5	13.3	13.3	13.3	13.2	13.1	13.4
Зээлийн ЖДХ**	19.5	19.1	19.7	19.1	20.1	19.7	20.2
Ипотекийн зээлийн ЖДХ	9.90	8.82	8.81	7.74	8.68	10.31	9.58
ТБҮЦ-ны ЖДХ	12.1	13.0	12.0	10.5	16.0	14.5	14.0
Бодлогын хүү	12.00	13.00	12.00	10.50	15.00	14.00	14.00
БХЗ-ын ЖДХ	12.20	11.84	12.55	11.33	15.87	15.51	14.54

** Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт

Тухайн сард M2 мөнгөний нийлүүлэлт 1.6 хувь буюу 195.8 тэрбум төгрөгөөр буурч 11.9 их наяд төгрөгт хүрчээ. Үүнд M1 мөнгө 6.6 хувь, бусад хадгаламж, харилцах 0.6 хувиар буурсан нь нөлөөлөв.


M1 мөнгөний өөрчлөлтөд төгрөгийн харилцах 75.9 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 61.8 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ. M1 мөнгөний M2 мөнгөнд эзлэх хувийн жин өмнөх сараас 0.9 нэгж хувиар буурч 16.4 хувь болжээ.

Бусад хадгаламж, харилцах буурахад гадаад валютын хадгаламж 8.5 хувиар буурсан нь нөлөөлөв. Энэ нь ерөнхийдөө байгууллагуудын гадаад валютын хадгаламжийн бууралтаар тайлбарлагдаж байна. **Иргэдийн хувьд гадаад валютын хадгаламжаа төгрөгийн хадгаламжинд шилжүүлсэн хандлага ажиглагдлаа.** Тухайлбал иргэдийн гадаад валютын хугацаагүй хадгаламж 97.7 тэрбум төгрөг, хугацаатай хадгаламж 27.9 тэрбум төгрөгөөр буурсан бол төгрөгийн хадгаламж 162.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Нийт төгрөгийн хадгаламж 127.8 тэрбум төгрөг буюу 2.2 хувь, гадаад валютын харилцах 50.0 тэрбум төгрөг буюу 3.5 хувиар өссөн байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол гадаад валютын хадгаламж өмнөх сараас 7.5 хувиар буурч, гадаад валютын харилцах 4.6 хувиар өсчээ.


Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮




Зураг 3. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)




Гадаад, дотоод актив

- Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл, 2017 оны 1 дүгээр сарын байдлаар хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 214.6 тэрбум төгрөгөөр буурч, дотоод цэвэр актив 18.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад актив 476.6 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудын гадаад пассив 187.6 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.
- Хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр авлага өмнөх сараас 129.7 тэрбум төгрөгөөр буурч 17.0 их наяд тэрбум төгрөг болжээ. Үүнд хувийн хэвшлээс авах авлага 149.4 тэрбум төгрөг, Засгийн газраас авах цэвэр авлага 65.9 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлөв. Харин иргэдээс авах авлага өмнөх сараас 105.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.
- Тайлант сард нөөц мөнгө 226.3 тэрбум төгрөгөөр буурч 2838.1 тэрбум төгрөг болжээ. Үүнд банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламж 138.8 тэрбум төгрөг, хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 61.8 тэрбум төгрөг, банкуудын касс дахь мөнгө 25.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Зураг 4. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 5. Нөөц мөнгө




Санхүүгийн байгууллагын зээл

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 81.7 тэрбум төгрөгөөр буурч 16.4 их наяд төгрөг болжээ. Зээлийн бууралтын 42.7 тэрбум төгрөг нь хадгаламжийн байгууллагын, 38.9 тэрбум төгрөг нь бусад санхүүгийн байгууллага (МИК, Хөгжлийн банк зэрэг)-ын зээлийн үлдэгдэл буурсантай холбоотой байна.

2017 оны 1 дүгээр сарын эцсийн байдлаар санхүүгийн байгууллагуудын зээлийн 75.6 хувийг хадгаламжийн байгууллагууд, 24.4 хувийг бусад санхүүгийн байгууллагуудын олгосон зээл бүрдүүлж байна. Нийт зээлийн

Зураг 6. Санхүүгийн байгууллагуудын зээл




48.3 хувийг иргэдэд, 45.0 хувийг хувийн хэвшилд, 6.6 хувийг улсын байгууллагуудад олгожээ.

Зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.3 нэгж хувиар өсч 10.2 хувь болжээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсч 7.6 хувьд хүрэв. Хугацаа хэтэрсэн зээлийн 71.6 хувь, чанаргүй зээлийн 80.3 хувийг хувийн хэвшилд олгосон зээл эзэлж байна.

Хадгаламжийн байгууллагуудын нийт зээлд хугацаа хэтэрсэн зээл 7.6 хувь, чанаргүй зээл 8.5 хувийг эзэлж байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 7.0 хувийг эзэлж байна.

Зураг 7. Санхүүгийн байгуудллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл



Мөнгөний зах

Тухайн сард банкууд банк хоорондын захаар дамжуулан 788.5 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Үүний 40.4 хувийг Төв банкны үнэт цаасны арилжаа, 39.8 хувийг овернайт зээл, 12.8 хувийг банк хоорондын хадгаламж, 7.0 хувийг репо арилжаа тус тус бүрдүүлжээ.

Банкууд 2017 оны 1 дүгээр сарын 4-ний өдрөөс 1 дүгээр сарын 31-ний өдрийн хооронд заавал байлгах нөөцийн шаардлага хангах зорилгоор 2141.2 тэрбум төгрөгийг Монголбанк дахь харилцах дансандаа төвлөрүүлжээ.

Зураг 8. Банк хоорондын захын арилжааны дүн, хүү




Хүү

Мөнгөний бодлогын зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар Бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулж, 14.0 хувь болгох шийдвэр гаргасан. Үүнтэй холбоотойгоор банк хоорондын захын хүү өмнөх сараас 1.0 нэгж хувиар буурч 14.54 хувь болжээ. Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 0.5 нэгж хувиар буурч 14.0 болжээ.

Тайлант сард төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 0.3 нэгж хувиар өсч 13.4 хувь болжээ. Харин гадаад валютын

Зураг 9. Хүү



хадгаламжийн хүү төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 6.0 хувь байна. Тайлант сарын эцэст төгрөгийн харилцахын хүү 2.9 хувь, валютын харилцахын хүү 1.7 хувь байна.

Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж жилийн хүү өмнөх сараас 0.5 нэгж хувиар өсч 20.2 хувь болов. Харин зээлийн үлдэгдлээр жигнэсэн дундаж зээлийн хүү өмнөх сараас төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд 18.5 хувь байна.

Валютын ханш

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1.2 хувь буюу 30.1 төгрөгөөр чангарч 2459.44 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2488.38 төгрөг байв. 2017 оны 1 дүгээр сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2631.48, Хятадын юаньтай харьцах ханш 357.4, ОХУ-ны рубльтай харьцах ханш 40.91 байна.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 1.0 хувиар буурсан буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш суларсан байна.

Зураг 10. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100

